



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 4/09

Улаанбаатар хот

Ахмадын сан байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, Монгол Улсын Засгийн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн хамгааллын тусгай төвийн "Ахмадын сан" байгуулж ажилласугай.
2. Нийгмийн хамгааллын тусгай төвийн тухайн жилийн батлагдсан төсвийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган тус санд төвлөрүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч (Б.Энхдолгор)-д даалгасугай.
3. "Ахмадын сан" байгуулсантай холбогдон байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулан, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн удирдлагын албаны дарга (Л.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.МӨНХЦЭЦЭГ

